

Бид танд шинэ ажил олоход тань туслана

Хэрэв та ажлын хомсдол, өвчин эсвэл түр хугацааны ажил дууссан шалтгаанаар ажлаас халагдсан бол Trygghetsfonden TSL-ээс шинэ ажил олох, хувийн бизнес эхлүүлэх эсвэл сурч эхлэхдээ тусламж авах боломжтой. Тус дэмжлэг нь таны ажлын байранд хамаарах хамтын гэрээний нэг хэсэг бөгөөд танд үнэ төлбөргүй.

Дэмжлэгт энэ багтана

Бид нөхцөл байдалд тань тулгуурлан замд тань туслах хувийн ажлын дасгалжуулагч санал болгож байна. Ажлын дасгалжуулагч танд тухайлбал, холбогдох хүн олох, өргөдөл эсвэл ажил мэргэжлийн намтар бичих, эсвэл ярилцлагад бэлтгэхэд тань туслана. Та мөн Försäkringskassan, Arbetsförmedlingen зэрэг байгууллагуудтай харилцахдаа дэмжлэг авах боломжтой.

Хэрэв та өвчний улмаас онцгой хэрэгцээтэй бол хөдөлмөрийн чадвараа үндэслэн шинэ ажилд орох зорилготойгоор эрүүл мэнддээ тохирсон, сайжруулсан дэмжлэг авах боломжтой.

Хэрэв хөдөлмөрийн зах зээлд нийцэх чадварыг тань нэмэгдүүлж, таныг шинэ ажилд хурдан хүргэх боломжтой сургалт бий бол тэрэнд таныг хамруулах боломжтой байж болох юм. Та мөн баталгаажуулах тусламж буюу, аль хэдийн чаддаг зүйлээ харагдахуйц болгож, баталгаажуулах тусламж авч болно.

Хэрэв та 40 нас хүрсэн бол халагдсаны тэтгэмж (AGB) гэж нэрлэгддэг санхүүгийн тэтгэмж авах эрхтэй байж болно.

Хэрэв та шинэ мэргэжлээр урт хугацаагаар суралцах хүсэлтэй бол Trygghetsfonden TSL-ээс ажил, мэргэжлийн чиг баримжаа авах тусламж авах боломжтой. Мөн сурах хугацаандаа өмнөх орлогынхоо дийлэнхийг хэвээр үлдээх санхүүгийн дэмжлэг авах янз бүрийн боломж бий.

Энэ нь дараах байдалтай байна:

Хэрэв та ажлын хомсдлын улмаас ажлаас халагдсан бол ажил олгогч болон үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгч энэхүү дэмжлэгийг авах хүсэлт гаргана. Хэрэв та өвчний улмаас ажлаас халагдсан эсвэл түр ажлаас халагдсан бол өөрөө хүсэлт гаргаж болно. Хүсэлтийг манай TSL.se вэбсайт дээр гаргана.

1. Trygghetsfonden TSL тантай холбогдож таны нөхцөл байдлын талаар болон цаашид ямар дэмжлэг авч болох талаар ярилцана.
2. Хэрэв та цаашид дэмжлэг авах бол танд туслах хувийн ажлын дасгалжуулагч олгоно.
3. Ажлын дасгалжуулагч таны шинэ ажилд орох, суралцах, бизнес эхлүүлэх замд тань туслана.
4. Шаардлагатай бол сургалтад хамрагдах боломж бас олгогдоно.
5. Хэрэв та 40-өөс дээш настай бол Afa Försäkring-аас халагдсаны тэтгэмж (AGB) хүсэхэд тусламж авч болно.

Дэмжлэг авах үндсэн болзлууд:

- Та хамгийн сүүлд Svenskt Näringsliv болон LO-гийн гэрээний хүрээнд хамтын гэрээтэй компанид ажиллаж байсан.
- Та сүүлийн 24 сарын дор хаяж 12-ынх нь хугацаанд ажилласан.
- Та 65 нас хүрээгүй.

Дэмжлэгийн тодорхой хэсэгт нэмэлт болзлууд хамаарна.

Дэлгэрэнгүй мэдээлэл ба ганцаарчилсан тусламж

Дэмжлэгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг манай TSL.se вэбсайтаас авах боломжтой. Сайтын дээд талд хэлээ өөрчлөх боломжтой хэрэгсэл бий.

Ганцаарчилсан тусламж авахын тулд бидэнтэй холбоо барина уу:

- Утсаар: 010-480 91 20
- Цахим шуудангаар: info@tsl.se